



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Хурлын хороог байгуулж,
бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалт, 45 дугаар зүйлийн 45.2, 45.5 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий дараах хороодыг байгуулсугай. Үүнд:

- 1) Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо
- 2) Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо
- 3) Төсвийн зарцуулалтын хяналтын хороо
- 4) Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хороо
- 5) Ногоон хөгжил, газрын харилцааны хороо
- 6) Хот байгуулалт, дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн хороо
- 7) Хүний эрх, ёс зүй, өргөдлийн хороо
- 8) Үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хороо

2. Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорооны ажиллах журмыг нэгдүгээр, бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06, 2022 оны 06 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

150100107

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 10 дугаар сарын 23-ний
өдрийн 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Хурлын хорооны ажиллах журам

Нэг. Журмын зорилго

1.1. Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид "Хурал" гэх/-ын хорооны үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2. Хурлын хороо нь Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангаж, Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэж, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хоёр. Хурлын хороо байгуулах, бүрэлдэхүүн, даргыг сонгох

2.1. Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаар Хурлын хороог энэхүү журмын 2.3 дахь хэсэг болон орон нутгийн онцлогийг баримтлан байгуулна.

2.2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шатанд нам, эвслийн бүлэг, бүлэгт харьяалагдаагүй төлөөлөгчдөөс Ажлын шаардлагыг харгалзан урьдчилан санал авсны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хугацаанд ажиллах хороог тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаас санал оруулан хэлэлцүүлж батлуулна.

2.3. Хурлын даргаас оруулсан саналыг хуралдаанаар хэлэлцэн олонхын саналаар хорооны бүрэлдэхүүнийг батална.

2.4. Хурлын хороог байгуулж, бүрэлдэхүүнийг баталсны дараа хурал түр завсарлаж, хороо бүр тусгайлан хуралдаж, олонхын санал авсан Төлөөлөгчийг Хурлын хорооны даргад нэр дэвшүүлнэ.

2.5. Хурлын хорооны болон Хурлын хуралдаан дээр Хурлын хорооны даргад нэр дэвшигчээс асуулт асууж хариулт авна.

2.6. Хурлын хорооны даргыг сонгосон тухай саналыг Хурлын хорооноос даалгасан аль нэг Төлөөлөгч танилцуулах бөгөөд хуралдаанаас тогтоол гаргана.

Гурав. Хурлын хороодын бүтэц

3.1. Хурал нь өөрийн нутаг дэвсгэр, хүн амын тоо газар зүйн байршил, аж ахуй нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлог, төлөөлөгчдийн тоог харгалзан хороог 5-7 гишүүнтэйгээр сонгож байгуулна. Хорооны нэр, бүтэц бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах асуудлыг ИТХ-ын хуралдаанаар шийдвэрлэнэ.

3.2.Хурал нь хариуцах ажлын онцлог, хэмжээ далайц, цаг үеийн хэрэгцээ шаардлагыг харгалзан хороодын харьяанд дэд хороо, түр хороо ажлын хэсгийг байгуулан ажиллуулж болно.

3.3.Хурал нь дараах чиглэл бүхий хороог байгуулж ажиллуулна:

- 3.3.1. Эрх зүй, нутгийн удирдлага;
- 3.3.2. Төсөв санхүү, эдийн засаг;
- 3.3.3. Төсвийн зарцуулалт, хяналт;
- 3.3.4. Нийгэм, цахим бодлого;
- 3.3.5. Ногоон хөгжил, газрын харилцаа;
- 3.3.6. Хот байгуулалт, дэд бүтэц, гэр хорооллын хөгжил;
- 3.3.7. Хүний эрх, жендер, ёс зүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлт;
- 3.3.8. Үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт;

3.4.Орон нутгийн хөгжлийн бодлого, чиглэл, цаг үеийн шаардлага, гаргасан шийдвэрийн хэрэгжилт, иргэдийн эрэлт хүсэлтийг үндэслэн дэд хороо, түр хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

3.5.Хороодод хариуцсан ажлын чиглэлээр нутаг дэвсгэрийн хүрээний байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, Засаг даргын тамгын газар, түүний дэргэдэх газар хэлтэс, албад, УТҮГ зэргийг татан оролцуулж, ажиллуулна.

3.6.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь Хүний эрх, ёс зүй, өргөдлийн хорооны бүрэлдэхүүнд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь нам, эвслийн болон бие даагчийн төлөөллийг бүрэн хамруулах, орон нутагт хүний эрхийг дээдлэх, нийгмийн шударга ёсыг хэрэгжүүлэх туршлага, манлайлах чадвараар илүү Төлөөлөгчөөс бүрдүүлэх зарчмыг удирдлага болгож сонгоно.

3.7.Хурлын хорооны хурлыг тухайн хурлын хорооны дарга удирдан гишүүддээ ажил үүрэг хуваарилж, хорооны гишүүдийн ажлыг дүгнэн хуралдаанд ажлаа тайлагнаж, санал, дүгнэлт гаргах тэмдэглэл, албан бичигт гарын үсэг зурна.

Дөрөв.Хороодын үйл ажиллагааны чиглэл

4.1.Хурлын хороод нь дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх, судлах, санал, дүгнэлт гаргах асуудлаар хорооны гишүүд, дэд хороодыг оролцуулж хуваарь гарган ажиллуулж дүн, мэдээллийг хорооны хурлаар хэлэлцэж санал, дүгнэлтээ нэгтгэнэ.

4.2.Байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, холбогдох иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэд, сонгогчид, судлаачдын санал бодлыг судалж санал, дүгнэлтийг боловсруулна.

4.3. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлаар болон гаргасан шийдвэрийн талаар иргэд, хамт олонд мэдээлэл өгөх, ярилцлага, хэлэлцүүлэг, сургалт хийх, нээлттэй сонсгол хийх, өдөрлөг, уулзалт зохиох зэрэг олон нийтэд зориулсан арга хэмжээг зохион байгуулж ажиллана.

4.4. Хорооны гишүүдийг эрхэлсэн ажил, мэргэжил, мэргэшил, туршлага, саналыг харгалзан хоёроос илүүгүй хороо, дэд хороо, түр хороонд ажиллуулах боломжоор хангана.

4.5. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас гаргасан шийдвэр болон төлөөлөгчдөөс гаргасан санал, дүгнэлтийн мөрөөр хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт гарган, шаардагдах тогтоол, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын хамт хорооны болон дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тухай бүр хэлэлцүүлж ажиллана.

4.6. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн болон тухайн жилийн эдийн засаг, нийгмийн зорилтын биелэлт, төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл, хандивын хөрөнгийн зарцуулалтад хяналт шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт гаргаж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд мэдээлнэ.

4.7. Хороод нь шийдвэрийн төсөл боловсруулах, биелэлт, үр дүнг дүгнэхдээ иргэд сонгогчид, хамт олон, иргэний нийгмийн байгууллагуудын санал авах, үнэлгээ хийлгэх, нийгэм эдийн засгийн болон сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж болно.

4.8. Орон нутгийн хэмжээний зарим асуудлаар иргэд, иргэний нийгмийн байгууллагын саналыг үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Хурлын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал боловсруулж, өргөн мэдүүлнэ.

4.9. Хурлын хороо нь нутгийн удирдлагын болон төрийн үйлчилгээний байгууллага, албан тушаалтанд асуулга тавих, асуулгын биелэлт, үр дүнгийн мөрөөр хийх ажилд хяналт тавьж ажиллана.

4.10. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас гаргах шийдвэрийн төсөлд Хороо, дэд хорооноос гаргасан горимын саналыг тусгах талаар санал хурааж шийдвэрлүүлнэ.

Тав. Хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт

5.1. Хурлын хороо нь ажлын төлөвлөгөөг жилээр боловсруулах бөгөөд төлөвлөгөөнд зохион байгуулах үйл ажиллагаа, хугацаа, шаардагдах зардлыг тодорхой тусгаж, Хурлын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Хурлын даргаар батлуулна.

5.2. Хурлын хорооны үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хорооны хуралдаан байна.

5.3.Хурлын хорооны хуралдааныг улирал тутам болон шаардлагатай тохиолдолд тухай бүр хуралдуулж асуудлаа хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.4.Хурлын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаар бэлтгэсэн баримт бичгээ гишүүддээ нэгээс доошгүй өдрийн өмнө хүргүүлсэн байна.

5.5.Хурлын Зөвлөл хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгүүлэхээр хорооны хуралдааны тов, хуваарийг тогтоох ба зохион байгуулалтын болон бусад асуудлаар тухайн хорооны дарга хуралдааныг зарлан хуралдуулна.

5.6.Хурлын хорооны дарга хуралдаанаа удирдана. Хорооны даргын эзгүйд хорооны даргын санал болгосноор хорооны хорооны аль нэг гишүүн хуралдааныг удирдана.

5.7.Хурлын хорооны хуралдаанд гишүүн бүр оролцох бөгөөд нийт гишүүдийн 50-аас дээш хувийн гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж, асуудлыг олонхоор шийднэ. Хорооны ажилд гишүүн бүр идэвх, санаачилгатай, ажил хэрэгч байдлаар оролцох үүрэгтэй.

5.8.Хурлын хорооны хурлын тэмдэглэлийг тухай бүр хөтлөх бөгөөд санал, дүгнэлт гаргах, асуулга тавих, хуралдаанд болон хорооны хуралд оруулсан асуудал, албан тушаалтанд өгсөн албан бичиг, зөвлөмж, түүний хариу авсан судалгаа мэдээлэл, өргөдөл хүсэлт, түүний дагуу хийсэн ажил зэрэг нь хорооны ажлын үндсэн бичиг баримт байна.

5.9.Хурлын хорооноос Засаг дарга, түүний харьяа байгууллага, аж ахуйн нэгжид өгөх албан бичиг, саналаа дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад танилцуулна.

5.10.Хурлын хороо нь хариуцсан ажлынхаа чиглэлээр эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулах саналаа дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд шийдвэрлүүлнэ.

5.11.Хурлын хороо нь хэлэлцсэн асуудлаар санал, дүгнэлт гаргах бөгөөд зохион байгуулсан үйл ажиллагааг иргэд олон нийтэд танилцуулж байна.

5.12.Хурлын хороо нь хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх ба хорооны дарга, гишүүд нь хуралдаанд таслах эрхтэй оролцоно.

5.13.Хурлын хорооны нарийн бичгийн дарга нь Хурлын Ажлын албаны ажилтан байх бөгөөд хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж, хорооны дарга, гишүүдтэй байнгын холбоотой ажиллана.

5.14.Хурлын хорооны нарийн бичгийн дарга нь хорооны дарга гишүүдийг мэдээ мэдээллээр хангах, хорооны хурлыг зохион байгуулах бэлтгэлийг хангах, хуралдаанд оролцогчдод зар хүргэх, хурлын байр, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах хурлын дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөх, албажуулах, хурлын хорооны шийдвэрийн төслийг боловсруулах зэрэг ажлыг зохион байгуулна.

5.15.Хурлын хорооны хийх ажлын төлөвлөгөөтэй холбоотой санхүүжилтийг Хурлын ажлын албаны тухай жилийн төсөвт тусган захиран зарцуулна.

Зургаа.Хурлын хорооны даргын чиг үүрэг

6.1.Хурлын хорооны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

6.1.1.Хурлын хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох байгууллага, албан тушаалтныг оролцуулан боловсруулна.

6.1.2.Хурлын хорооны хурлын бэлтгэлийг хангаж, зохион байгуулж хуралдуулна.

6.1.3.Хурлын хорооны хуралдааныг удирдана.

6.1.4.Хурлын хорооны нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцана.

6.1.5.Хурлын хорооны ажлыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцан тайлагнана.

6.1.6.Хурлын хорооны даргыг өөрчлөх саналыг тухайн хорооны гишүүдийн олонхын санал болгосноор Хурлын дарга хуралдаанаар хэлэлцүүлэхээр асуудал оруулж болно.

Долоо.Хорооны эрхлэх асуудал, үйл ажиллагааны чиглэл

7.1.Хороод нь дараах эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

7.1.1. Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо:

А.Эрх зүйн бодлого, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн хэрэгжилт, хяналт шалгалт

Б.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Тамгын газар, хороо, харьяа хэлтэс, албадын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа

В.Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа

Г.Гамшгаас урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа

Д.Улс төрийн нам, сүм хийд шашны байгууллагатай харилцах асуудал

Е.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

Ё.Дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа бодлого, үйл ажиллагаа

Ж.Иргэний танхимын үйл ажиллагаа

7.1.2. Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо:

А.Дүүргийн төсөв, санхүү, татварын бодлого, үйл ажиллагаа

Б.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

В.Орон нутгийн хөгжлийн сан

Г.Татварын орлогын бүрдүүлэлт, эх үүсгэврийг нэмэгдүүлэх боломж, энэ талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт

Д.Дүүргийн хөгжлийн хандлагыг тодорхойлох үндсэн чиглэл, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт

Е.Гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн бодлого

Ё.Орон нутгийн өмч, газрын харилцааны бодлого, удирдлага, зохицуулалт

Ж.Орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт

7.1.3. Төсвийн зарцуулалтын хяналтын хороо:

А.Дүүргийн төсвийн зарцуулалт, түүний гүйцэтгэл

Б.Дүүргийн төсөв, санхүү, татварын бодлого, үйл ажиллагаа

В.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл

Г.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Д.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалт

Е.Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжийн үр ашиг, үр нөлөө

Ё.Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн

Ж.Дотоод аудитын үйл ажиллагаа

7.1.4. Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хороо:

А.Хүн амын эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, спорт

Б. Боловсрол

В.Соёл урлаг

Г.Шинжлэх ухаан

Д.Хүн ам зүйн бодлого, зохицуулалт

Е.Ахмадын бодлого, дүүргийн ахмадын хорооны үйл ажиллагаа

Ё.Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн бодлого, үйл ажиллагаа

Ж.Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа

З.Цахим төрийн алба, төрийн үйлчилгээ

И.Төрийн байгууллагын цахим мэдээллийн сүлжээ, системийг сайжруулах үйл ажиллагаа

7.1.5. Ногоон хөгжил, газрын харилцааны хороо:

А.Байгаль орчин, экологийн асуудал, хууль тогтоомжийн хэрэгжилт

Б.Орон нутгийн тусгай хамгаалалттай газар

В.Ногоон бүсийн газар нутгийг ашиглах, эзэмшүүлэх, хамгаалах асуудал

Г.Байгаль орчны хяналт

Д.Агаар, хөрсний бохирдол, тохижилт орчны цэвэрлэгээ

Е.Усны бодлого, гол мөрөн, булаг шандын хамгаалалтын дэглэм

Ё.Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт

Ж.Хог хаягдлын менежмент

З.Газрын тухай хуулийн хэрэгжилт

И.Газар ашиглах, эзэмшүүлэх, өмчлөлийн тухай

7.1.6. Хот байгуулалт, дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн хороо:

А.Барилга хот байгуулалт

Б.Дэд бүтэц, зам, талбайн тохижилт

В.Гэр хорооллын хөгжлийн бодлого, төсөл хөтөлбөр

Г.Хороо хөгжүүлэх бодлоготой холбоотойгоор хэрэгжих гадаад орны болон олон улсын байгууллагын зээл тусламжийн асуудал

Д.Эрчим хүч, гэрэлтүүлэг

Е.Зам, нийтийн тээвэр, шуудан, харилцаа холбоо

Ё.Орон сууц, нийтийн аж ахуй

Ж.Тохижилт, нийтийн аж ахуй, цэвэрлэгээ үйлчилгээ

3.Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд

7.1.7. Хүний эрх, ёс зүй, өргөдлийн хороо:

А.Хүний эрхийн баталгааны талаар судалгаа хийх бодлого боловсруулах, хүний эрхийн зөрчлийн асуудлаар хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх

Б.Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хяналт

В.Хурлын хуралдааны дэгийн биелэлт

Г.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих

Д.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих

Е.Санал асуулга, олон нийтийн санаа бодлын тандалт судалгаа

7.1.8. Үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хороо:

А.Хүнсний болон хөнгөн үйлдвэрийн бодлого

Б.Хүнсний бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал

В.Үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого

Г.Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах бодлого

Д.Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого

Е.Нийгмийн хамгааллын бодлого, үйл ажиллагаа

Ё.Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа

Ж.Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгаалал

7.2.Хороодын үйл ажиллагааны чиглэл, эрхлэх асуудлын хүрээг хурал өөрөө тогтооно.

Найм. Бусад

8.1.Хурлын хорооноос өгсөн зөвлөмжийн биелэлт, албан бичгээр шаардсан мэдээ, судалгааг тогтоосон цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж мэдээлж байх үүргийг Засаг даргын Тамгын газар, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага хүлээнэ.


8.2.Хариуцсан ажлынхаа чиглэлээр Хурлын хорооны дарга, гишүүдээс байгууллага, хамт олны ажилтай танилцах, хүмүүстэй уулзаж ярилцах, сэтгэл ханамжийн болон бусад судалгаа авах ажлыг зохион байгуулж, оролцуулах үүргийг тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага хариуцна.

8.3.Хурлын хороо, түүний гишүүдийн ажлын сайн туршлага, санаачилгыг төв, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах ажлыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар хариуцаж ажиллана.

8.4.Хороо нь үйл ажиллагааны зардалтай байх бөгөөд зардлыг Хурлын төсвөөс тухай бүр санхүүжүүлнэ.

8.5.Энэ журамд шаардлагатай гэж үзвэл дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 10 дугаар сарын 23-ний
өдрийн 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Хурлын хорооны бүрэлдэхүүн

1. Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо:

Дарга: Д.Мөнхтөр
Гишүүд: Х.Алтаншагай
Н.Бямбагэрэл
З.Бямбажав
Б.Ерөө
Э.Уянга
А.Эрдэнэбат

2. Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо:

Дарга: Ц.Содхүү
Гишүүд: Д.Буянтогтох
Э.Ганчимэг
А.Лхагвадорж
Б.Нямдорж
З.Очирбат
С.Энхтайван

3. Төсвийн зарцуулалтын хяналтын хороо:

Дарга: Н.Сайнболд
Гишүүд: Х.Алтаншагай
Б.Батсайхан
Н.Бямбагэрэл
О.Есөнтөмөр
Т.Уламбаяр
Ж.Чимэдцогзол

4. Нийгэм, цахим бодлогын хөгжлийн хороо:

Дарга: Д.Отгонбаатар
Гишүүд: Ц.Амаржаргал
С.Баярсайхан
А.Ганбаатар
Д.Уянга
Ч.Хонгорзул
Л.Цэеэрэгзэн

5. Ногоон хөгжил, газрын харилцааны хороо:

Дарга: Ч.Болормаа
Гишүүд: Ц.Амаржаргал
А.Лхагвадорж
Г.Өлзийбаатар
Э.Уянга
Ч.Хонгорзул
А.Эрдэнэбат

6.Хот байгуулалт, дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн хороо:

Дарга: Д.Ядамжав
Гишүүд: Б.Батсайхан
Д.Буянтогтох
Б.Мөнхбат
Ш.Нарантунгалаг
Г.Өлзийбаатар
С.Уянгазул

7.Хүний эрх, Ёс зүй, өргөдлийн хороо:

Дарга: Б.Болортунгалаг
Гишүүд: А.Ганбаатар
Э.Ганчимэг
Б.Ерөө
Ш.Мөнх-Оргил
З.Очирбат
Т.Уламбаяр

8.Үйлдвэрлэл үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хороо:

Дарга: Н.Доржпүрэв
Гишүүд: З.Бямбажав
С.Баярсайхан
О.Есөнтөмөр
Ш.Мөнх-Оргил
Ш.Нарантунгалаг
С.Уянгазул